

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан аргачлалын дагуу үнэ тарифыг тооцож боловсруулахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын захирал, дарга нарт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ, тарифын тооцоо, саналыг хянахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган), аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны “Аргачлал батлах тухай” 231 дүгээр тогтоол, 2016 оны “Журам шинэчлэн батлах тухай” 53 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ, ТАРИФЫГ ТОГТООХ АРГАЧЛАЛ

1. Ерөнхий зүйл
2. Нэр томъёоны тайлбар
3. Үндсэн зарчим
4. Тарифын зохицуулалтын хугацаа
5. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тодорхойлох
 - 5.1. Хөрөнгийн /Капитал/ зардал
 - 5.1.1. Өгөөж тооцох хөрөнгө
 - 5.1.2. Хөрөнгийн өгөөжийн хувь
 - 5.1.3. Элэгдэл, хорогдлын зардал
 - 5.2. Үйл ажиллагааны хянагдах зардал
 - 5.2.1. Түлшний зардал
 - 5.2.2. Үйл ажиллагааны бусад хянагдах зардал
 - 5.3. Үйл ажиллагааны үл хянагдах зардал
 - 5.4. Залруулга
6. Үнэ тариф тогтоох
 - 6.1. Үйлдвэрлэх ТЗЭ-ийн үнэ
 - 6.1.1. Энергийн тариф
 - 6.1.2. Чадлын тариф
 - 6.2. Дамжуулах үйлчилгээний төлбөр буюу тариф
 - 6.3. Диспетчерийн зохицуулалт хийх үйлчилгээний төлбөр буюу тариф
 - 6.4. Түгээх, зохицуулалттай хангах үйлчилгээний төлбөр буюу тариф
 - 6.5. Хэрэглэгчийн үнэ тариф
 - 6.5.1. Хэрэглэгчийн дундаж үнэ
 - 6.5.2. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф
 - 6.6. Эрчим хүчний бус үйл ажиллагааг давхар эрхэлж буй ТЗЭ /орон сууц, нийтийн аж ахуй, цэвэр бохир усны хангамж г.м./-ийн тариф
 - 6.7. Шинээр үйл ажиллагаа явуулж буй /санхүүгийн түүхгүй/ ТЗЭ-ийн тариф
7. Элэгдэл, хорогдол тооцох хувь буюу ашиглалтын хугацаа
8. Нэмэлт нөхцөл
9. Хэмнэлт, үр ашгийн хуваарилалтыг тооцох
10. Бусад

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /2015-2030/”, Засгийн газрын 2018 оны 325 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр /2018-2023/-д нийцүүлэн цахилгаан, дулаан үйлдвэрлэх үнэ, диспетчерийн зохицуулалт хийх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “ТЗЭ” гэх/-ийн үйлчилгээний төлбөр, тариф, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтооход оршино.

1.2. Энэхүү үнэ тарифын аргачлал нь “Урамшуулалд суурилсан” болон “Зардал дээр нэмэх” зарчимд үндэслэн ТЗЭ-ийн үйл ажиллагааны үр ашгийг дэмжсэн, бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангахад чиглэгдсэн байна.

2. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд:

Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (БОШХ) – Тухайн жилийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд шаардлагатай зардал, зохих ашгийн дүн бүхий Зохицуулах хорооноос хянаж тооцсон орлогын дүн;

Шаардлагатай /зохих хэмжээний/ зардал – Хамгийн бага өртгийн зарчмын дагуу тусгай зөвшөөрлийн хэвийн, найдвартай үйл ажиллагаанд шаардлагад нийцүүлэн Зохицуулах хорооноос хянаж тооцсон зардал;

Хөрөнгийн /капитал/ зардал – Хөрөнгө оруулалтын өгөөж болон элэгдэл, хорогдлын зардал;

Үйл ажиллагааны үл хянагдах зардал – ТЗЭ нь дотооддоо хянан зохицуулах боломжгүй, гадны хүчин зүйлээс хамаардаг зардал;

Үйл ажиллагааны хянагдах зардал – ТЗЭ-ийн дотоод хүчин зүйлээс хамаардаг зардал;

Үр ашгийн фактор (Х-фактор) – Бүтээмж болон үйл ажиллагааны үр ашгийн өсөлтийн түвшин;

Хөрөнгө оруулалт – Үндсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж буй их засвар, хөрөнгө худалдан авалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардал;

Хөрөнгийн өгөөж – Зохицуулалттай хөрөнгийн дүнд капиталын жигнэсэн дундаж өртгөөр тооцох өгөөжийн түвшин;

Тарифын зохицуулалтын хугацаа – Зохицуулах хорооноос тогтоосон үнэ тариф хянан тогтоох (3-аас 5 жил) хугацаа;

Тариф мөрдөх жил (t+1) – Зохицуулалтын хугацаан дахь тухайн жил;

Тариф тооцох жил (t) – Тарифын тооцоолол хийгдэх, зохицуулалтын хугацааны өмнөх жил;

Тооцооллын өмнөх жил (t-1) – Тариф тооцох жилийн өмнөх буюу холбогдох гүйцэтгэлүүд баталгаажсан жил;

Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт (ХҮИ) – Жил бүрийн инфляци буюу хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт;

Хөндлөн татаас - Цахилгааны тарифт шингээх дулааны үйлдвэрлэлийн санхүүгийн алдагдлын хэмжээ;

Үйлчилгээний биет хэмжээ - Үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх цахилгаан, дулааны эрчим хүчний тоо хэмжээ;

Чадлын тариф - үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахилгааны бөөний зах зээлд сар бүр чадал нийлүүлэхэд бэлэн байлгасны төлбөр;

Энергийн тариф - үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бөөний зах зээлд гэрээний дагуу нийлүүлэх цахилгааны нэгж кВт.ц бүрт төлөх үнэ;

3. ҮНДСЭН ЗАРЧИМ

3.1. Тухайн тарифын зохицуулалтын хугацааны тариф мөрдөх жил (t+1) тутмын эрчим хүчний үнэ тарифыг энэхүү аргачлалын дагуу тооцно.

3.2. ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Хөрөнгийн /Капитал/ зардал;
- Үйл ажиллагааны хянагдах зардал;
- Үйл ажиллагааны үл хянагдах зардал;
- ~~Нормативт алдагдлын зардал.~~

3.3. Хөрөнгийн /Капитал/ зардал болон үйл ажиллагааны үл хянагдах зардлыг “Зардал дээр нэмэх” зарчмын дагуу тооцно.

3.4. Үйл ажиллагааны хянагдах зардлыг “Урамшуулалд суурилсан” зарчмын дагуу тооцно.

3.5. Тариф тогтоох хугацааны үйлчилгээний биет хэмжээ, худалдан авах эрчим хүчний хэмжээг тодорхойлоход ЭХЗХ-оос тогтоосон дотоод хэрэгцээний цахилгаан, дулааны зарцуулалт, шугамын алдагдал, үйлдвэрлэлт, түгээлтийн төлөвлөгөөнд үндэслэнэ.

3.6. Төлбөрт бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого /холбогдох зардал нь үйл ажиллагааны зардалд бүртгэгддэг/ болон санхүүжилтийн эх үүсвэр нь Засгийн газрын эрх бүхий байгууллагаар баталгаажсан нөхцөлд татаасыг тарифын тооцоонд оруулж тооцно.

3.7. Үнэ тариф тооцох зардалд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд хамааралгүй бүх төрлийн шагнал урамшуулал тэтгэмж, бусдад өгсөн хандив, бэлэг дурсгал, хүлээн авалт, туслах аж ахуй, амралт, сувилал, гуанз, цайны газрын зардал ба бусад үйлдвэрлэлийн бус үйлчилгээний зардлыг оруулахгүй.

3.8. Дамжуулах, түгээх, хангах ТЗЭ-ийн худалдах, худалдан авах эрчим хүчний хэмжээний өөрчлөлт, хэрэглээний бүтэц, хэрэглэгчийн үнийн өөрчлөлтөөс хамааран хэрэглэгчийн дундаж үнэд өөрчлөлт орж, орлого нэмэгдэх тохиолдолд үйлчилгээний хувьсах ба тогтмол төлбөрт нийцүүлэн худалдан авах үнэд өөрчлөлт оруулна. Харин орлого буурсан тохиолдолд ТЗЭ санал ирүүлбэл борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд нийцүүлэн худалдан авах үнэд зохих өөрчлөлт оруулна.

3.9. ТЗЭ-ийн суурилагдсан хүчин чадал, үйлчилгээний хамрах хүрээ өөрчлөгдсөн нь тухайн ТЗЭ-ийн санхүүгийн чадавхид нөлөөлөхүйц байх тохиолдолд худалдах, худалдан авах үнэд зохих өөрчлөлт оруулна.

3.10. Хэрэглэгчийн цахилгааны дундаж үнийг тогтооход ашиглагдах эрчим хүчний нэгдсэн системд хамаарах бүх ТЗЭ-ийн индексжүүлсэн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг үндэслэнэ.

3.11. Бүх төрлийн үнэ тарифуудыг нэмэгдсэн өртгийн албан татвар ороогүй дүнгээр тооцно.

3.12. Тарифын зохицуулалтын тухайн хугацаа дуусахаас өмнө энэхүү аргачлалын 4-д заасны дагуу дараагийн тарифын зохицуулалтын хугацааны тариф мөрдөх жил (t+1) тутмын эрчим хүчний үнэ тарифыг тогтооно.

3.13. Тарифын зохицуулалтын тухайн хугацаанд гарсан хэмнэлт, үр ашгийг зохицуулалтын дараагийн хугацаанд хуваарилж болно.

3.14. Эрчим хүчний хэрэглээ, эх үүсвэрийн өөрчлөлт болон бусад шалтгааны улмаас тухайн нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулааны хангамжийн хүрээнд хэрэглэгчийн тарифын орлого буурах, хүрэлцэхгүй тохиолдолд нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тооцсон БОШХ-д ижил хувь хэмжээгээр өөрчлөлт оруулж болно.

4. ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУГАЦАА

4.1. Тарифын зохицуулалтын хугацааг ТЗЭ тус бүрд тодорхойлно.

4.2. Тариф мөрдөх жилүүдийн ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ, үнэ тарифыг тооцооллын өмнөх жил (t-1)-ийн гүйцэтгэлүүдэд үндэслэн тариф тооцох жил (t)-д хянан тооцож тогтооно.

4.3. Тарифын зохицуулалтын хугацаанд тооцох хөрөнгийн өгөөжийн хувь болон үр ашгийн факторын хувь хэмжээг тодорхойлно.

5. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ШААРДАГДАХ ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг дараах томъёоны дагуу тооцно:

$$\text{БОШХ}_{(t+1)} = \text{ХЗ}_{(t+1)} + \text{ҮАХЗ}_{(t+1)} + \text{ҮАҮХЗ}_{(t+1)} + \text{Зал}_{(t+1)}$$

- ХЗ_(t+1) - Хөрөнгийн зардал;
- ҮАХЗ_(t+1) - Үйл ажиллагааны хянагдах зардал;
- ҮАҮХЗ_(t+1) - Үйл ажиллагааны үл хянагдах зардал;
- Зал_(t+1) - Залруулга буюу Зохицуулах хорооноос хянаж тооцсон зардал, орлого болон тэдгээрийн бодит гүйцэтгэлийн зөрүү;

5.1. Хөрөнгийн /Капитал/ зардал

Хөрөнгийн /Капитал/ зардлыг дараах томъёоны дагуу тооцно:

$$\text{ХЗ}_{(t+1)} = (\text{ӨТХ}_{(t+1)} \times \text{ХӨ}\%) + \text{ЭЗ}_{(t+1)}$$

- ӨТХ_(t+1) - Өгөөж тооцох хөрөнгийн дүн;
- ХӨ% - Хөрөнгийн өгөөжийн хувь;
- ЭЗ_(t+1) - Элэгдлийн зардал;

5.1.1. Өгөөж тооцох хөрөнгө

Өгөөж тооцох хөрөнгийн дүн, түүний төлөвлөсөн хөрөнгө оруулалтыг Зохицуулах хороо /тарифын зохицуулалтын зорилгоор/ хянах ба хөрөнгийн үнэлгээг Historic Cost Valuation Method, боломжгүй бол Replacement Cost asset method-аар авч үзнэ. Өгөөж тооцох хөрөнгийн дүнг дараах томъёоны дагуу тооцно:

$$\text{ӨТХ}_{(t+1)} = \text{БХ}_{(t-1)} + \text{ББХ}_{(t-1)} - \text{ҮТХ}_{(t-1)} - \text{АХХ}_{(t-1, t, t+1)} + \text{ХО}_{\text{Төл}(t, t+1)} - \text{ЭЗ}_{\text{Төл}(t, t+1)} - \text{ҮТХ}_{\text{Төл}(t, t+1)} + \text{ЭЗҮТХ}_{\text{Төл}(t, t+1)}$$

- БХ_(t-1) - Өмнөх жилийн эцсийн биет хөрөнгийн цэвэр дүн;
- ББХ_(t-1) - Өмнөх жилийн эцсийн биет бус хөрөнгийн цэвэр дүн;
- ҮТХ_(t-1) - Өмнөх жилийн эцсийн бусдаас үнэ төлбөргүй авсан хөрөнгийн цэвэр дүн;
- АХХ_(t-1, t, t+1) - Тооцооллын өмнөх жил, тариф тооцох жил, тариф мөрдөх жилүүдэд ашиглалтаас хасах хөрөнгийн дүн;
- ХО_{Төл(t, t+1)} - Тариф тооцох жил, тариф мөрдөх жилд Зохицуулах хорооноос хянан зөвшөөрсөн нэмэгдэх хөрөнгө /хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардал/-ийн дүн;

- $\text{ЭЗ}_{\text{төл}}(t, t+1)$ - Тариф тооцох жил, тариф мөрдөх жилд байгуулах элэгдэл, хорогдлын зардал;
- $\text{ҮТХ}_{\text{төл}}(t, t+1)$ - Тариф тооцох жил, тариф мөрдөх жилд бусдаас үнэ төлбөргүй авах хөрөнгийн дүн;
- $\text{ЭЗҮТХ}_{\text{төл}}(t, t+1)$ - Бусдаас үнэ төлбөргүй авсан хөрөнгөнд тариф тооцох жил, тариф мөрдөх жилд байгуулах элэгдэл хорогдлын зардал;

5.1.2. Хөрөнгийн өгөөжийн хувь

5.1.2.1. Хөрөнгийн өгөөжийн хувийг капиталын жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлох ба тарифын зохицуулалтын хугацаанд тогтмол байна.

5.1.2.2. Хөрөнгийн өгөөжийн хувийг дараах томъёоны дагуу тооцно:

$$\text{ХӨ}\% = \text{УХЗ}\% \times \text{ЗХ}\% + (\text{ЭӨ}\% \times \text{ЭӨЗ}\%) / (1 - \text{АТ}\%)$$

- $\text{УХЗ}\%$ - Урт хугацаат зээлийн нийт өмч ($\text{УХЗ} + \text{ЭӨ}$)-д эзлэх хувь
- $\text{ЗХ}\%$ - Урт хугацаат зээлийн зардал /хүү/-ын хувь
- $\text{ЭӨ}\%$ - Эзэмшигчийн өмчийн нийт өмч ($\text{УХЗ} + \text{ЭӨ}$)-д эзлэх хувь
- $\text{ЭӨЗ}\%$ - Эзэмшигчийн өмчийн зардал /ашиг/-ын хувь
- $\text{АТ}\%$ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь

5.1.2.3. Урт хугацаат зээл болон эзэмшигчийн өмчийн зардлын хувийг томъёоны дагуу тооцно:

$$\text{ЗХ}\% = \text{ЭХ}\% + \text{ЗНҮ}\%$$

$$\text{ЭӨЗ}\% = \text{ЭХ}\% + \beta \times (\text{ЗЗЭ}\% - \text{ЭХ}\%)$$

- $\text{ЭХ}\%$ - Эрсдэлгүй хүүгийн хувь
- $\text{ЗНҮ}\%$ - Зээлийн нэмэгдэл хүүгийн хувь
- $\text{ЗЗЭ}\%$ - Зах зээлийн эрсдлийн хүүний хувь
- β - Холбогдох салбарын эрсдлийн хүчин зүйл

5.1.2.4. Урт хугацаат зээлийн нийт өмч ($\text{УХЗ} + \text{ЭӨ}$)-д эзлэх хувийг **70%** гэж тооцно.

5.1.2.5. Зохицуулах хороо нь эрсдэлгүй хүүгийн хувь ($\text{ЭХ}\%$), салбарын эрсдлийн хүчин зүйл (β), зах зээлийн эрсдлийн хүүгийн нэмэгдэл ($\text{ЗЗЭ}\% - \text{ЭХ}\%$), зээлийн нэмэгдэл хүүгийн хувь ($\text{ЗНҮ}\%$)-ийг тарифын зохицуулалтын хугацаа тус бүрд тогтмол байдлаар тогтооно.

5.1.3. Элэгдэл, хорогдлын зардал

5.1.3.1. Энэхүү аргачлалын 7-д заасан хөрөнгийн ашиглагдах хугацааг ашиглан элэгдэл, хорогдлын зардлыг шулуун шугамын аргаар тооцно.

5.1.3.2. Элэгдэл, хорогдлын зардалд дараах хөрөнгөнд байгуулсан элэгдэл, хорогдлыг тооцохгүй. Үүнд:

- тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд ашиглагдахгүй;
- бусдаас үнэ төлбөргүй /Засгийн газрын буцалтгүй тусламж, улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хандив, тусламжаар/ авсан;
- газар;

- г) худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй;
- д) дуусаагүй барилга;
- е) түр ашиглаагүй буюу нөөцөд байгаа;
- ж) дахин үнэлгээ хийж нэмэгдсэн хөрөнгийн үнийн зөрүү;

5.1.3.3. ТЗЭ хөрөнгийн дахин үнэлгээ хийхээс өмнө мэдэгдэх ба Зохицуулах хороо дахин үнэлгээтэй холбоотой элэгдлийн зардлыг борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд нэмж тусгах боломжтой эсэх талаар мэдэгдэнэ. Хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн дүнгийн зөрүүнд тооцсон элэгдлийн зардлыг дахин үнэлгээ хийх үндэслэл, хөрөнгийн ашиглалтын байдал, дахин үнэлгээ хийсэн тайлан болон бусад холбогдох мэдээллийг харгалзан үзсэн үндсэн дээр тарифын тооцоонд тусгах эсэхийг шийдвэрлэнэ.

~~5.1.3.4. Хөрөнгийн ашиглалтын хугацааг техникийн болон хөрөнгийн паспорт, бэлтгэн нийлүүлэгчээс ирүүлсэн баримт бичиг, хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын нөхцөл зэргийг харгалзан техникийн болон санхүүгийн ажилтнууд өрөлцсөн комиссын дүгнэлтийг үндэслэн өөрчлөн тооцож болно.~~

5.1.3.5. Энэхүү аргачлалын 7-д заасан үндсэн хөрөнгийн төрөлд хамааруулах боломжгүй эсвэл шинэ нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа, элэгдлийн хувь хэмжээг тогтоохдоо ашиглалтын болон үйл ажиллагааны хувьд адил төстэй хөрөнгөтэй жишиг байдлаар тодорхойлно.

~~5.1.3.6. Хөрөнгийн ашиглахаар тооцсон хугацаанд өөрчлөлт өрсөн үед элэгдлийн хувь хэмжээг дахин тооцоолж болно.~~

~~5.1.3.7. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд тусгагдах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэх их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлыг байгууллагын эрсдлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын үр ашгийг тодорхой аргачлалаар тооцсоныг үндэслэн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд тусгаж болно.~~

5.2. Үйл ажиллагааны хянагдах зардал

Үйл ажиллагааны хянагдах зардал нь дараах үндсэн 2 зардлаас бүрдэнэ. Үүнд:

- Түлшний зардал;
- Үйл ажиллагааны бусад хянагдах зардал.

5.2.1. Түлшний зардал

Үйлдвэрлэх ТЗЭ-ийн түлшний зардалд нүүрс, мазут, галлагааны бусад түлш, түлшний тээвэр болон бусад зардлууд хамаарах бөгөөд дараах томъёоны дагуу тооцно:

$$ТЗ_{(t+1)} = [\sum (ЖТ_{(t+1)} \times ТЭХ_{\%(t-1)} \times 7000 / ТИ_{(t-1)} \times ТҮ_{(t-1)}) + ТБЗ_{(t-1)}] \times (1 + ХҮИ_t - X_t) \times (1 + ХҮИ_{(t+1)} - X_{(t+1)})$$

ЖТ _(t+1)	-	Тариф мөрдөх жишмэл түлшний зарцуулалт;
ТЭХ _{\%(t-1)}	-	Тооцооллын өмнөх жилийн түлшний төрлийн эзлэх хувь;
ТИ _(t-1)	-	Тооцооллын өмнөх жилийн түлшний илчлэг;
ТҮ _(t-1)	-	Тооцооллын өмнөх жилийн түлшний үнэ;
ТБЗ _(t-1)	-	Тооцооллын өмнөх жилийн түлшний бусад зардал;
ХҮИ _t	-	Тариф тооцох жилийн инфляцийн дундаж түвшин;
X _t	-	Тариф тооцох жилийн үр ашгийн фактор;
ХҮИ _(t+1)	-	Тариф мөрдөх жилийн инфляцийн дундаж түвшин;
X _(t+1)	-	Тариф мөрдөх жилийн үр ашгийн фактор;

Жишмэл түлшний зарцуулалт:

$$\text{ЖТ}_{(t+1)} = \text{ҮБХ}_{\text{цах}(t+1)} \times \text{ЖТХЗ}_{\text{цах}(t-1)} + \text{ҮБХ}_{\text{дул}(t+1)} \times \text{ЖТХЗ}_{\text{дул}(t-1)}$$

- $\text{ҮБХ}_{\text{цах}(t+1)}$ - Тариф мөрдөх жилийн цахилгааны үйлчилгээний биет хэмжээ;
 $\text{ЖТХЗ}_{\text{цах}(t-1)}$ - Тооцооллын өмнөх жилийн цахилгааны жишмэл түлшний хувийн зарцуулалт;
 $\text{ҮБХ}_{\text{дул}(t+1)}$ - Тариф мөрдөх жилийн дулааны үйлчилгээний биет хэмжээ;
 $\text{ЖТХЗ}_{\text{дул}(t-1)}$ - Тооцооллын өмнөх жилийн дулааны жишмэл түлшний хувийн зарцуулалт;

Түлшний үнэ:

$$\text{ТҮ}_{(t-1)} = \text{ТГҮ}_{(t-1)} + \text{ТТҮ}_{(t-1)}$$

- $\text{ТГҮ}_{(t-1)}$ - Түлшний газар дээрх үнэ;
 $\text{ТТҮ}_{(t-1)}$ - Түлшний тээврийн үнэ.

5.2.2. Үйл ажиллагааны бусад хянагдах зардал

5.2.2.1. ТЗЭ-ийн дотоод хүчин зүйл буюу гаргаж буй шийдвэрээс хамаарч өөрчлөгддөг дараах зардлуудыг үйл ажиллагааны хянагдах зардалд авч үзнэ. Үүнд:

- Үйл ажиллагаанд ашиглах ус, цахилгаан;
- Түүхий эд материал, шатахуун, тээвэр, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, материал, хангамжийн материал;
- Цалин, шимтгэл;
- Ашиглалтын цахилгаан, дулаан, ус;
- Албан томилолт, конторын хангамж, харилцаа холбоо;
- Гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл;
- Борлуулалт, маркетинг;
- Түрээс;
- Сургалт;
- Найдваргүй авлагын хасагдуулга;
- Ажиллагсдын нийгмийн зардал;
- Бусад /Банкны богино хугацаат зээлийн хүү болон үйл ажиллагааны зардалд хамаарах бусад зардлууд/;

5.2.2.2. Тарифын жилийн үйл ажиллагааны хянагдах зардлыг дараах томъёоны дагуу тооцно:

$$\text{ҮАХЗ}_{(t+1)} = \text{ҮАХЗ}_{(t-1)} \times (1 + \text{ХҮИ}_t - \text{Х}_t) \times (1 + \text{ХҮИ}_{(t+1)} - \text{Х}_{(t+1)})$$

- $\text{ҮАХЗ}_{(t-1)}$ - Тооцооллын өмнөх жилийн үйл ажиллагааны хянагдах зардлын гүйцэтгэл;
 ХҮИ_t - Тариф тооцох жилийн инфляцийн дундаж түвшин;
 Х_t - Тариф тооцох жилийн үр ашгийн фактор;
 $\text{ХҮИ}_{(t+1)}$ - Тариф мөрдөх жилийн инфляцийн дундаж түвшин;
 $\text{Х}_{(t+1)}$ - Тариф мөрдөх жилийн үр ашгийн фактор;

5.2.2.3. Тариф тооцох жилийн дундаж инфляцийн дундаж түвшин (ХҮИ_t)-г Монгол Улсын ($t-3$) оны Хэрэглээний үнийн индексийг ($t-2$) онтой харьцуулж тодорхойлно.

5.2.2.4. Тарифын (t+1) жилийн инфляцийн дундаж түвшин (ХҮИ_(t+1))-г Монгол Улсын (t-2) оны Хэрэглээний үнийн индексийг (t-1) онтой харьцуулж тодорхойлно.

5.3. Үйл ажиллагааны үл хянагдах зардал

5.3.1. ТЗЭ нь дотооддоо хянан зохицуулах боломж бага, гадны хүчин зүйлээс голлон хамаардаг дараах зардлуудыг үйл ажиллагааны үл хянагдах зардалд авч үзнэ. Үүнд:

- Харуул хамгаалалт;
- Хөдөлмөр хамгаалалт;
- Даатгал;
- Байгаль орчин хамгаалах;
- Галын аюулаас хамгаалах;
- Диспетчерийн зохицуулалтын хөлс;
- Зохицуулалтын үйлчилгээний хөлс;
- Гадны үйлчилгээний хөлс;
- Үл хөдлөх хөрөнгийн татвар;
- АТӨЯХ-ийн албан татвар;
- Газрын төлбөр;
- Бусад татвар хураамж;
- Бусад /Борлуулалтын шимтгэл болон үйл ажиллагааны зардалд хамаарах

бусад зардлууд/;

5.3.2. Тарифын жилийн үйл ажиллагааны үл хянагдах зардлыг дараах томъёоны дагуу тооцно:

$$YAUX3_{(t+1)} = YAUX3_{(t-1)} \times (1 + XUI_t) \times (1 + XUI_{(t+1)})$$

$YAUX3_{(t-1)}$ - Тооцооллын өмнөх жилийн үйл ажиллагааны үл хянагдах зардлын гүйцэтгэл;

XUI_t - Тариф тооцох жилийн инфляцийн дундаж түвшин;

$XUI_{(t+1)}$ - Тариф мөрдөх жилийн инфляцийн дундаж түвшин;

5.4. Залруулга

5.4.1. Дараах хүчин зүйлс өөрчлөгдсөний улмаас борлуулалтын орлогын шаардагдах хэмжээний өмнөх зохицуулалтын хугацааны тарифт тооцсон дүн бодит гүйцэтгэлд гарсан зөрүүг дараагийн зохицуулалтын хугацаанд Зохицуулах хороо залруулж болно. Үүнд:

- а) Хөрөнгийн өгөөж;
- б) Элэгдлийн зардал;
- в) Үйл ажиллагааны зардал;
- г) Үйл ажиллагааны орлого;
- д) Шугамын нормативт алдагдал;
- е) Үндсэн бус үйл ажиллагааны ашиг.

5.4.2. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд хийх залруулгыг дараах томъёоны дагуу тооцно:

$$Зал_{(t+1)} = ЗХӨ_{(t+1)} + ЗЭЗ_{(t+1)} + ЗҮАЗ_{(t+1)} - ЗҮАО_{(t+1)} + ЗШНА_{(t+1)} - YABA_{(t+1)}$$

- зХӨ_(t+1) - Хөрөнгийн өгөөжийн тооцсон дүн ба бодит гүйцэтгэлийн зөрүүг залруулах дүн;
- зЭЗ_(t+1) - Элэгдлийн зардлын тооцсон дүн ба бодит гүйцэтгэлийн зөрүүг залруулах дүн;
- зҮАЗ_(t+1) - Үйл ажиллагааны зардлын тооцсон дүн ба бодит гүйцэтгэлийн зөрүүг залруулах дүн;
- зҮАО_(t+1) - Үйл ажиллагааны орлогын тооцсон дүн ба бодит гүйцэтгэлийн зөрүүг залруулах дүн;
- зШНА_(t+1) - Шугамын нормативт алдагдлын тооцсон дүн ба бодит гүйцэтгэлийн зөрүүнээс үүссэн зардлыг залруулах дүн;
- зҮАБА_(t+1) - Үйл ажиллагааны бус ашгийн дүн.

Хөрөнгийн өгөөжийн залруулга:

$$\text{зХӨ}_{(t+1)} = [(\text{бӨТХ}_{(t-1)} - \text{тӨТХ}_{(t-1)}) \times \text{ХӨ}_{\%(t-1)}] \times (1 + \text{ХӨ}_{\%(t-1)}) \times (1 + \text{ХӨ}_{\%t})$$

- бӨТХ_(t-1) - Өгөөж тооцох хөрөнгийн бодит гүйцэтгэл;
- тӨТХ_(t-1) - Өгөөж тооцох хөрөнгийн тооцсон дүн;
- ХӨ% - Хөрөнгийн өгөөжийн хувь.

Элэгдлийн зардлын залруулга:

$$\text{зЭЗ}_{(t+1)} = (\text{бЭЗ}_{(t-1)} - \text{тЭЗ}_{(t-1)}) \times (1 + \text{ХӨ}_{\%(t-1)}) \times (1 + \text{ХӨ}_{\%t})$$

- бЭЗ_(t-1) - Элэгдлийн зардлын бодит гүйцэтгэл;
- тЭЗ_(t-1) - Элэгдлийн зардлын тооцсон дүн;
- ХӨ% - Хөрөнгийн өгөөжийн хувь.

Үйл ажиллагааны зардлын залруулга:

$$\text{зҮАЗ}_{(t+1)} = (\text{бҮАЗ}_{(t-1)} - \text{тҮАЗ}_{(t-1)}) \times (1 + \text{ХӨ}_{\%(t-1)}) \times (1 + \text{ХӨ}_{\%t})$$

- бҮАЗ_(t-1) - Үйл ажиллагааны зардлын бодит гүйцэтгэл;
- тҮАЗ_(t-1) - Үйл ажиллагааны зардлын тооцсон дүн;
- ХӨ% - Хөрөнгийн өгөөжийн хувь.

Үйл ажиллагааны орлогын залруулга:

$$\text{зҮАО}_{(t+1)} = [(\text{бҮБХ}_{(t-1)} - \text{тҮБХ}_{(t-1)}) \times \text{T}_{(t-1)}] \times (1 + \text{ХӨ}_{\%(t-1)}) \times (1 + \text{ХӨ}_{\%t})$$

- бҮБХ_(t-1) - Үйлчилгээ (цахилгаан, дулаан)-ний биет хэмжээний бодит гүйцэтгэл;
- тҮБХ_(t-1) - Үйлчилгээ (цахилгаан, дулаан)-ний биет хэмжээний тооцсон дүн;
- T_(t-1) - Үнэ тариф;
- ХӨ% - Хөрөнгийн өгөөжийн хувь.

Шугамын нормативт алдагдлын зардлын залруулга:

$$\text{зШНА}_{(t+1)} = [\text{бШНА}_{(t-1)} \times \text{бТ}_{\text{хацд}(t-1)} - \text{тШНА}_{(t-1)} \times \text{тТ}_{\text{хацд}(t-1)}] \times (1 + \text{ХӨ}_{\%(t-1)}) \times (1 + \text{ХӨ}_{\%t})$$

$бШНА_{(t-1)}$	- Шугамын нормативт алдагдлын биет хэмжээний бодит гүйцэтгэл;
$тШНА_{(t-1)}$	- Шугамын нормативт алдагдлын биет хэмжээний тооцсон дүн;
$бТ_{\text{хацд}(t-1)}$	- Худалдан авах цахилгаан, дулааны эрчим хүчний бодит үнэ тариф;
$тТ_{\text{хацд}(t-1)}$	- Худалдан авах цахилгаан, дулааны эрчим хүчний тооцсон үнэ тариф;
$ХӨ\%$	- Хөрөнгийн өгөөжийн хувь.

6. ҮНЭ ТАРИФ ТОГТООХ

ТЗЭ-ийн эрчим хүчний тарифыг цахилгаан, дулаан үйлдвэрлэх, диспетчерийн зохицуулалт хийх, дамжуулах, түгээх, хангах ТЗЭ тус бүрээр тогтооно.

6.1. Үйлдвэрлэх ТЗЭ-ийн үнэ

Үйлдвэрлэх ТЗЭ-ийн үнэ тариф нь цахилгаан, дулаан үйлдвэрлэх үнэ (хувьсах зардлыг нөхөх энергийн тариф) ба боломжит чадлын зардлыг нөхөх үнэ (тогтмол зардлыг нөхөх чадлын тариф)-ээс бүрдэнэ.

6.1.1. Энергийн тариф

Үйлдвэрлэх төлөвлөгөөнд тусгагдсан эрчим хүч үйлдвэрлэж, түгээх үйл ажиллагааны хувьсах зардалд үндэслэн энергийн тарифыг тооцно.

$$T_{\text{энерги}(t+1)} = \frac{YA3_{\text{хувь}(t+1)} + зҮЗ_{(t+1)}}{YBX_{(t+1)}}$$

$YA3_{\text{хувь}(t+1)}$	- Үйл ажиллагааны хувьсах зардал;
$зҮЗ_{(t+1)}$	- Түлшний /нүүрс, мазутын үнэ, түлшний тээврийн хөлс г.м./-ийн үнийн зөрүүгээс үүсэх ашиг, алдагдал;
$YBX_{(t+1)}$	- Нийлүүлэх үйлчилгээ (цахилгаан, дулаан)-ний биет хэмжээ.

Үйл ажиллагааны хувьсах зардал:

$$YA3_{\text{хувь}(t+1)} = T3_{(t+1)} + A3YX3_{(t+1)}$$

$T3_{(t+1)}$	- Түлшний зардал;
$A3YX3_{(t+1)}$	- Ашиглалт, засвар, үйлчилгээний хувьсах зардал: үйлдвэрийн хэрэглээний ус, түүнтэй холбоотой татвар болон түүхий эд материал /химийн ус цэвэрлэгээний материал/, засвар үйлчилгээний зардлууд.

Түлшний үнийн зөрүүгээс үүсэх ашиг, алдагдал:

$$зҮЗ_{(t+1)} = [бТЗарц_{(t+1)} \times (бТҮ_{(t-1)} - тТҮ_{(t-1)})] \times (1 + ХӨ\%_{(t-1)}) \times (1 + ХӨ\%_t)$$

$бТЗарц_{(t+1)}$	- Түлшний бодит зарцуулалтын гүйцэтгэл;
$бТҮ_{(t-1)}$	- Түлшний үнийн бодит гүйцэтгэл;
$тТҮ_{(t-1)}$	- Түлшний тооцсон үнэ;
$ХӨ\%$	- Хөрөнгийн өгөөжийн хувь.

Үйл ажиллагааны үзүүлэлтийн өөрчлөлтөөс үүсэх ашиг, алдагдал:

$$\Delta YAY_{(t+1)} = [BYBX_{(t-1)} \times TTY_{(t-1)} \times (BHTZ_{(t-1)} - THTZ_{(t-1)})] \times (1 + X\Theta_{\%(t-1)}) \times (1 + X\Theta_{\%t})$$

- BYBX_(t-1)** - Үйлчилгээ (цахилгаан, дулаан)-ний биет хэмжээний бодит гүйцэтгэл;
TTY_(t-1) - Түлшний тооцсон үнэ;
BHTZ_(t-1) - Нэгжийн түлшний бодит зарцуулалт;
THTZ_(t-1) - Нэгжийн тооцсон түлшний зарцуулалт;
XΘ_{\%(t-1)} - Хөрөнгийн өгөөжийн хувь.

Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх ТЗЭ-ийн үйлдвэрлэх үйл ажиллагааны хувьсах зардлыг нэгж цахилгаан, дулааны эрчим хүчинд ногдох хэмжээнд үндэслэн хуваарилна.

6.1.2. Чадлын тариф

Үйлдвэрлэх төлөвлөгөөнд тусгагдсан эрчим хүч үйлдвэрлэж, түгээх үйл ажиллагааны тогтмол зардлыг нөхөх байдлаар чадлын тарифыг тооцно.

Хувилбар 1: Чадал бэлэн байлгасан хоног тутмын (сар тутам байж болно) төлбөр

$$T_{\text{чадал}(t+1)} = \frac{YAZ_{\text{тогт}(t+1)} + XZ_{(t+1)} \pm XT_{(t+1)}}{\Theta T_{(t+1)}} = \frac{BO\text{ШX}_{\text{үйлд}(t+1)} - YBX_{(t+1)} \times T_{\text{энерги}(t+1)}}{\Theta T_{(t+1)}}$$

- YAZ_{тогт(t+1)}** - Үйл ажиллагааны тогтмол зардал;
XZ_(t+1) - Хөрөнгө /капитал/-ийн зардал;
XT_(t+1) - Бүтээгдэхүүн хоорондын хөндлөн татаас;
ΘT_(t+1) - Боломжит чадлыг бэлэн байлгасан өдрийн тоо;
BOШX_{үйлд(t+1)} - Үйлдвэрлэх үйл ажиллагааны БОШХ.

Хувилбар 2: Батлагдсан төлөвлөгөөний дагуу нэгж бүтээгдэхүүны чадлын тариф.

- Батлагдсан төлөвлөгөөнөөс илүү үйлдвэрлэсэн цахилгаан, дулаанд чадлын төлбөр тооцохгүй,

- Батлагдсан төлөвлөгөөнөөс бага үйлдвэрлэж нийлүүлсэн нь ТЗЭ-ээс шалтгаалсан бол буурсан цахилгаан, дулаанд чадлын төлбөр тооцохгүй,

- Батлагдсан төлөвлөгөөнөөс бага үйлдвэрлэж нийлүүлсэн нь ТЗЭ-ээс шалтгаалаагүй бол буурсан цахилгаан, дулаанд чадлын төлбөр тооцно,

$$T_{\text{чадал}(t+1)} = \frac{YAZ_{\text{тогт}(t+1)} + XZ_{(t+1)} \pm XT_{(t+1)}}{YBX_{(t+1)}} = \frac{BO\text{ШX}_{\text{үйлд}(t+1)} - YBX_{(t+1)} \times T_{\text{энерги}(t+1)}}{YBX_{(t+1)}}$$

- YAZ_{тогт(t+1)}** - Үйл ажиллагааны тогтмол зардал;
XZ_(t+1) - Хөрөнгө /капитал/-ийн зардал;
XT_(t+1) - Бүтээгдэхүүн хоорондын хөндлөн татаас;
YBX_(t+1) - Нийлүүлэх үйлчилгээ (цахилгаан, дулаан)-ний биет хэмжээ.
BOШX_{үйлд(t+1)} - Үйлдвэрлэх үйл ажиллагааны БОШХ.

Бүтээгдэхүүн хоорондын хөндлөн татаас:

$$ХТ_{(t+1)} = YAO_{дул(t+1)} - YA3_{дул(t-1)}$$

- YAO_{дул(t+1)} - Дулааны эрчим хүчний үйл ажиллагааны орлого;
 YA3_{дул(t+1)} - Дулааны эрчим хүчний үйл ажиллагааны зардал.

Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх ТЗЭ-ийн үйлдвэрлэх үйл ажиллагааны тогтмол болон хөрөнгийн зардлыг цахилгаанд 90, дулаанд 10 хувиар ногдуулж хуваарилна.

6.2. Дамжуулах үйлчилгээний төлбөр буюу тариф

Дамжуулах үйлчилгээний төлбөр буюу тарифыг дараах томъёоны дагуу тооцно:

$$T_{дамж(t+1)} = \frac{БОШХ_{дамж(t+1)}}{СТ_{(t+1)}}$$

- БОШХ_{дамж(t+1)} - Дамжуулах үйл ажиллагааны БОШХ;
 СТ_(t+1) - Үйл ажиллагаа явуулах сарын тоо.

6.3. Диспетчерийн зохицуулалт хийх үйлчилгээний төлбөр буюу тариф

Диспетчерийн зохицуулалт хийх үйлчилгээний төлбөр буюу тарифыг дараах томъёоны дагуу тооцно:

$$T_{дис(t+1)} = \frac{БОШХ_{дис(t+1)}}{СТ_{(t+1)}} = \frac{\sum (ДЗЗ_{ТЗЭ(t+1)} \times K_{ТЗЭ(t+1)})}{СТ_{(t+1)}}$$

- БОШХ_{дис(t+1)} - Диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагааны БОШХ;
 СТ_(t+1) - Үйл ажиллагаа явуулах сарын тоо;
 ДЗЗ_{ТЗЭ(t+1)} - ТЗЭ-чдийн төлөх диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний зардал;
 K_{ТЗЭ(t+1)} - Эрчим хүч түгээх хангах ТЗЭ тус бүрийн Диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох коэффициент.

Эрчим хүч түгээх хангах ТЗЭ тус бүрийн Диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох коэффициент

$$K_{ТЗЭ(t+1)} = \frac{БОШХ_{ТЗЭ(t+1)}}{\sum (БОШХ_{ТЗЭ(t+1)})}$$

- БОШХ_{ТЗЭ(t+1)} - Эрчим хүч түгээх хангах ТЗЭ тус бүрийн БОШХ;

6.4. Түгээх, зохицуулалттай хангах үйлчилгээний төлбөр буюу тариф

Түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг дараах томъёоны дагуу тооцно.

$$T_{түгээх(t+1)} = \frac{БОШХ_{түгээх(t+1)}}{СТ_{(t+1)}}$$

- БОШХ_{түгээх(t+1)} - Түгээх үйл ажиллагааны БОШХ;
 СТ_(t+1) - Үйл ажиллагаа явуулах сарын тоо.

Зохицуулалттай хангах үйлчилгээний төлбөр буюу тарифыг дараах томъёоны дагуу тооцно.

$$T_{\text{хангах}(t+1)} = T_{\text{хацд}(t+1)} = \frac{YBX_{\text{бор}(t+1)} \times T_{\text{дундаж}(t+1)} - \text{БОШХ}_{\text{хангах}(t+1)}}{YBX_{\text{хацд}(t+1)}}$$

- $T_{\text{хацд}(t+1)}$ - Худалдан авах цахилгаан, дулааны эрчим хүчний тариф;
 $YBX_{\text{бор}(t+1)}$ - Хэрэглэгчид борлуулах үйлчилгээний биет хэмжээ;
 $T_{\text{дундаж}(t+1)}$ - Хэрэглэгчид борлуулах дундаж үнэ;
 $\text{БОШХ}_{\text{хангах}(t+1)}$ - Хангах үйл ажиллагааны БОШХ;
 $YBX_{\text{хацд}(t+1)}$ - Худалдан авах үйлчилгээний биет хэмжээ (цахилгаан, дулаан).

Түгээх, хангах ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг түгээх үйл ажиллагаанд **90**, хангах үйл ажиллагаанд **10** хувиар ногдуулж хуваарилна.

6.5. Хэрэглэгчийн үнэ тариф

Энэхүү аргачлалаар хэрэглэгчийн тариф, дундаж тариф, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф зэргийг “зардал + зохих ашиг”-ийг нөхөх зарчмаар тодорхойлно.

6.5.1. Хэрэглэгчийн дундаж үнэ

Хэрэглэгчид борлуулах эрчим хүчний дундаж үнийг дараах томъёоны дагуу тооцно:

$$T_{\text{дундаж}(t+1)} = \frac{\sum [YBX_{\text{үйлд}(t+1)} \times T_{\text{үйлд}(t+1)}] + \sum [\text{БОШХ}_{\text{дамж, дис, түг, хан}(t+1)}] + YBX_{\text{имп}(t+1)} \times T_{\text{имп}(t+1)}}{YBX_{\text{бор}(t+1)}}$$

- $YBX_{\text{үйлд}(t+1)}$ - Үйлдвэрлэх ТЗЭ /уламжлалт болон сэргээгдэх эрчим хүч/-ийн үйлчилгээний биет хэмжээ;
 $T_{\text{үйлд}(t+1)}$ - Үйлдвэрлэх ТЗЭ-ийн үнэ тариф;
 $\text{БОШХ}_{\text{дамж, дис, түг, хан}(t+1)}$ - Дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, түгээх, зохицуулалттай хангах үйл ажиллагааны БОШХ;
 $YBX_{\text{имп}(t+1)}$ - Импортоор худалдан авах цахилгааны биет хэмжээ;
 $T_{\text{имп}(t+1)}$ - Импортоор худалдан авах цахилгааны үнэ тариф;
 $YBX_{\text{бор}(t+1)}$ - Хэрэглэгчид борлуулах үйлчилгээний биет хэмжээ.

6.5.2. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф

Сэргээгдэх эрчим хүчийг тарифыг дараах томъёоны дагуу тооцож тогтооно:

$$T_{\text{сэхд}(t+1)} = \frac{(T_{\text{уламж дундаж}(t+1)} - T_{\text{сэх, дундаж}(t+1)}) \times \sum (YBX_{\text{сэх}(t+1)})}{YBX_{\text{бор}(t+1)}}$$

- $T_{\text{уламж дундаж}(t+1)}$ - Уламжлалт /түлшээр ажиллах цахилгаан станц/ эрчим хүч үйлдвэрлэх ТЗЭ-ийн дундаж үнэ тариф;
 $T_{\text{сэх, дундаж}(t+1)}$ - Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэх ТЗЭ-ийн дундаж үнэ тариф;
 $YBX_{\text{сэх}(t+1)}$ - Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэх ТЗЭ-ийн үйлчилгээний биет хэмжээ;

$YBX_{\text{бор}(t+1)}$ - Хэрэглэгчид борлуулах үйлчилгээний биет хэмжээ.

Уламжлалт эрчим хүч үйлдвэрлэх ТЗЭ-ийн дундаж үнэ тариф:

$$T_{\text{уламж дундаж}(t+1)} = \frac{\Sigma (YBX_{\text{уламж}(t+1)} \times T_{\text{уламж}(t+1)})}{\Sigma YBX_{\text{уламж}(t+1)}}$$

$YBX_{\text{уламж}(t+1)}$ - Уламжлалт эрчим хүч үйлдвэрлэх ТЗЭ-ийн үйлчилгээний биет хэмжээ;

$T_{\text{уламж}(t+1)}$ - Уламжлалт эрчим хүч үйлдвэрлэх ТЗЭ-ийн үнэ тариф.

Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх ТЗЭ-ийн дундаж үнэ тариф:

$$T_{\text{сэх дундаж}(t+1)} = \frac{\Sigma (YBX_{\text{сэх}(t+1)} \times T_{\text{сэх}(t+1)})}{\Sigma YBX_{\text{сэх}(t+1)}}$$

$YBX_{\text{сэх}(t+1)}$ - Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх ТЗЭ-ийн үйлчилгээний биет хэмжээ;

$T_{\text{сэх}(t+1)}$ - Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх ТЗЭ-ийн үнэ тариф.

6.6. Эрчим хүчний бус үйл ажиллагааг давхар эрхэлж буй ТЗЭ /орон сууц, нийтийн аж ахуй, цэвэр бохир усны хангамж г.м./-ийн тариф

6.6.1. Дулаан түгээх, хангах үйл ажиллагааг орон сууц, нийтийн аж ахуйн үйл ажиллагаатай хамт эрхэлж буй дараах ТЗЭ нарын борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд тооцох зардлуудыг зохих аргачлалын дагуу хуваарилна. Үүнд:

а) Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл бүхий Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ОСНААУГ болон хувийн хэвшлийн ОСНАА-н компани, аж ахуйн нэгжүүд;

б) Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл бүхий бусад аймгийн төв, суурин газруудад үйл ажиллагаа явуулж буй ОСНАА-н компани, аж ахуйн нэгжүүд;

в) Дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл бүхий ОСНАА-н үйл ажиллагаа давхар эрхэлж буй компани, аж ахуйн нэгжүүд.

6.6.2. Нэг төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд олон тооны ТЗЭ үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд дараах үзүүлэлтүүдийг үндэслэн “шугаман тэгшитгэл”-ийн аргаар ТЗЭ нарын борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тодорхойлж, тэдгээрийн үнэ тарифыг багцлан тогтоож болно. Үүнд:

- Хэрэглэгчийн тоо /тарифын ангилал тус бүрээр/;
- Хэрэглээ /тарифын ангилал тус бүрээр/;
- Борлуулалтын орлого;
- Худалдан авах дулааны эрчим хүчний хэмжээ;
- Тоног төхөөрөмжийн мэдээлэл /тоо, ширхэг, урт, хөндлөн огтлол г.м./;

6.7. Шинээр үйл ажиллагаа явуулж буй /санхүүгийн түүхгүй/ ТЗЭ-ийн тариф

Шинээр үйл ажиллагаа явуулж буй ТЗЭ-ийн тарифыг тооцоходоо ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй бусад ТЗЭ-чдийн үзүүлэлтүүдийн дундаж /бенчмаркинг/ хэмжээнд үндэслэн “шугаман тэгшитгэл”-ийн аргаар борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тодорхойлж тогтоож болно.

7. ЭЛЭГДЭЛ, ХОРОГДОЛ ТООЦОХ ХУВЬ БУЮУ АШИГЛАЛТЫН ХУГАЦАА

ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд тусгах элэгдэл хорогдлын зардлыг доорх хүснэгтэд заасан ашиглалтын хугацааг үндэслэн тооцно.

№	Элэгдэл, хорогдол тооцох хөрөнгө	Хугацаа /жил/
Нэг. Барилга, байгууламж		
1	Төмөр бетон, угсармал байшин, төмөр сараалжтай ердийн, тоосгон болон блокон барилга	60
2	Холимог бүтэцтэй болон дүнзэн байшин	36
3	Зуслангийн модон байшин, угсармал болон бусад хөнгөвчилсэн хийцийн модон байшин	45
4	Үнсэн сан, үнс хаягдлын байгууламж	15
5	Зөөр, хүлэмж, малын хашаа	45
6	Услалтын систем, хөргөх цамхаг, усан сан, худаг,	20-25
7	Контейнер /төмөр чингэлэг/	20
8	Угсармал төмөр бетон далан	60
9	Цутгамал бетон далан	30
10	Асфальт бетон хучилттай зам, талбай	15
11	Цемент бетон хучилттай зам, талбай	25
Хоёр. Үйлдвэрийн тоног төхөөрөмж		
1	Бүх төрлийн зуух, зуухны тоног төхөөрөмж, халах гадаргуу	20-30
2	Бүх төрлийн турбин, турбины тоног төхөөрөмж	30-40
3	100 МВт хүртэл хүчин чадалтай бүх төрлийн генератор, дагалдах тоноглол	20-30
4	100 МВт буюу түүнээс дээш хүчин чадалтай генератор, дагалдах тоноглол	30-35
5	Өндөр даралтын уурын болон дулааны шугам хаалт	15
6	5-аас дээш м3 багтаамжийн шанагатай эксковатор, илчит тэрэг, цахилгаан зүтгүүр	15
7	32 ба түүнээс дээш м3 багтаамжтай думпкар, төрөл бүрийн бутлагч, шигшүүр, конвейер, нар салхины цахилгаан үүсгүүр	10
8	32 м3 хүртэл багтаамжтай думпкар, эрдэс түүхий эд боловсруулах төхөөрөмжүүд, туузан дамжуулагч	8
9	35 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй хуваарилах байгууламж, дэд өртөөний трансформатор, таслуур, бусад тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл кабель шугам	30-40
10	6,10,15кВ хүчдэлтэй хуваарилах байгууламж, дэд өртөөний трансформатор, таслуур, бусад тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, кабель шугам	20-30
11	1000В хүртэлх хүчдлийн хуваарилах байгууламж, трансформатор, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл	10-15
12	35кВ ба түүнээс дээш хүчдэлийн төмөр, төмөр бетон тулгуур бүхий агаарын шугам	40-45
13	35кВ хүртэл хүчдэлийн төмөр, төмөр бетон тулгуур бүхий агаарын шугам	30-35
14	35кВ ба түүнээс доош хүчдлийн модон тулгуур бүхий агаарын шугам	20-25
15	Эрчим хүчний тоолуур	8-15
16	Бүх төрлийн хөдөлгүүр ба насосууд	8
17	Ф500 мм ба түүнээс дээш голчтой дулааны шугам, хоолой /ил, газар доор/	30
18	Ф500 мм хүртэлх голчтой дулааны шугам, хоолой	25
19	Халаалтын болон хэрэглээний усны шугам, хоолой	25
20	Дохиолол хамгаалал, автоматикийн техник хэрэгсэл	10
21	Холбооны техник хэрэгсэл, зай тэжээлийн байгууламж, гар станц, суурийн аккумулятор, ачаа өргөх зөөх төхөөрөмж, жин хэмжүүр, багаж таль, тельфер	8
Гурав. Төмөр замын тээврийн хэрэгсэл		

1	Төмөр замын ул шороо, төмөр замын дээд хэсэг, төмөр бетон замын доорх гарц, төмөр замын хиймэл төхөөрөмж	100
2	Бүх төрлийн вагон, илчит тэрэг, цистерн, зорчигчийн тавцан, вагон угаах тавцан, гүүрэн кран, зам тавигч төхөөрөмжтэй балласжуулагч, моторт тавцан, зам цэвэрлэгч, шалгагч хэлбэлзэл шингээгчийг турших машин, сонгох холбооны зогсоогуур	25
3	Вагон кузов засварлах машин, дрезина, хос дугуйн голын хүзүү зүлгэх, дугуй зорох, вагон засварлах машин, цахилгаан домкрат, дугуйн өнхрөх гадаргууг зорох, зүтгүүрийн дугуй зорох машин, замын хориг хашаа, сонгох холбооны дундаж цэг шилжүүлэх байгууламж, зам хэмжигч	14
4	25 тоннын хос дугуйт домкрат, 15 тоннын шингэний домкрат, төмөр замаар явдаг кран, үе угсрах машин	11
5	Замаас авагддаг дрезина, өртөөний ажиллагааг хянах камерын систем, зөөврийн радио холбоо, автомат хадгаламж	8
6	Шруп эрэгдэгч, замын боолт болон шруп чангалагч, үе угсрах тавцан дэр модны цахилгаан чигжүүр, зам төмөр тайрагч, түлхэгч, зүлгэгч, механизм цасны хаалт, радио холбооны төхөөрөмж	5
7	Вагоны кузов угаах машин	5
8	Вагон пүүлэх хэмжих хэрэгсэл, тээвэрт хэрэглэгдэж байгаа чингэлэг	10
Дөрөв. Авто машин, тээврийн хэрэгсэл		
1	Ачааны болон суудлын автомашин	10
2	Тусгай зориулалтын машин механизм, тээврийн хэрэгсэл (Кран, өрмийн машин, авто самосвал бульдозер, автогрейдер, автобус, троллейбус, чиргүүл гэх зэрэг бусад)	15
Тав.Шатахууны тоног төхөөрөмж		
1	Түлш агуулах сав	20
2	Түгээгүүр, насос, ачих, буулгах төхөөрөмж	5
Зургаа. Тавилга эд хогшил		
1	Тавилга эд хогшил, Хөгжмийн хэрэгсэл, радио, телевиз, бие бялдаржуулах болон атлетикийн техник хэрэгсэл, Хөргөгч, хөлдөөгч, Эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжүүд, Ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж	10
2	Компьютер, техник хэрэгсэл	5-8
Долоо. Биет бус хөрөнгө		
1	Программ хангамж	10
2	Бусад биет бус хөрөнгө	10

8. НЭМЭЛТ НӨХЦӨЛ

8.1. Тарифын зохицуулалтын эхний хугацаанд хөрөнгийн өгөөжийн хувийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

а) Эрсдэлгүй хүүгийн хувь (ЭХ%) – 6.0% (МБ-ны бодлогын хүү)

б) Зээлийн нэмэгдэл хүүгийн хувь (ЗНҮ%) – 0.0%

в) Зах зээлийн эрсдлийн нэмэгдэл (ЗЗЭ%-ЭХ%) – 2.0% (Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү)

г) Салбарын эрсдлийн хүчин зүйлийн коэффициент (β) - 1.00

$$\text{КЖДӨ} = 70\% * (6.0\% + 0.0\%) + 30\% * (6.0\% + 1.00 * 2.0\%) / (1 - 10\%) = 6.87\%$$

8.2. Тарифын зохицуулалтын эхний хугацаанд үр ашгийн фактор ($X_{\text{фактор}}$)-ыг **2.0%** гэж тооцно.

8.3. Тарифын зохицуулалтын эхний хугацаа нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааг хамаарна.

8.4. Тарифын жилийн зардлын залруулга нь шаардлагатай тохиолдолд тарифын зохицуулалтын хугацааны 2 дахь жилээс хийгдэж болно.

9. ХЭМНЭЛТ, ҮР АШГИЙН ХУВААРИЛАЛТЫГ ТООЦОХ

9.1. Өмнөх тарифын зохицуулалтын хугацаанд ТЗЭ-ийн үйл ажиллагаанд гарсан үр ашиг, зардлын хэмнэлтийн **50** хувийг дараагийн зохицуулалтын хугацаанд хуваарилж шилжүүлнэ.

9.2. Шилжүүлэх үр ашгийн хуваарилалтыг дараах байдлаар тооцно. Үүнд:

$$\text{ШҮА}_{(n+i)} = \frac{(\text{ҮАӨ}_{(i)} + \text{ҮАӨ}_{(i+1)} + \dots + \text{ҮАӨ}_{(n)})}{(1+\text{ХӨ}\%)^i} \times 50\%$$

- n - Тарифын зохицуулалтын хугацаа, жил;
i - Тариф мөрдөх жилийн дугаар;
ҮАӨ - Үр ашгийн өсөлт;
ХӨ% - Хөрөнгийн өгөөжийн хувь.

Өмнөх тарифын зохицуулалтын хугацааны эхний жилийн үр ашгийн өсөлт:

$$\text{ҮАӨ}_{(1)} = (\text{ҮАЗ}_{\text{Тооц}(t+1)} - \text{ҮАЗ}_{\text{Гүйц}(t+1)}) - [(\text{ҮАЗ}_{\text{Тооц}(t)} - \text{ҮАЗ}_{\text{Гүйц}(t)}) - (\text{ҮАЗ}_{\text{Тооц}(t-1)} - \text{ҮАЗ}_{\text{Гүйц}(t-1)})] - \text{ОШҮАӨ}_{\text{Гүйц}(t-1)}$$

Өмнөх тарифын зохицуулалтын хугацааны (t+i) жилийн үр ашгийн өсөлт:

$$\text{ҮАӨ}_{(i)} = (\text{ҮАЗ}_{\text{Тооц}(t+i)} - \text{ҮАЗ}_{\text{Гүйц}(t+i)}) - (\text{ҮАЗ}_{\text{Тооц}(t+i-1)} - \text{ҮАЗ}_{\text{Гүйц}(t+i-1)});$$

Өмнөх тарифын зохицуулалтын хугацааны сүүлийн жилийн үр ашгийн өсөлт:

$$\text{ҮАӨ}_{(n)} = (\text{ҮАЗ}_{\text{Тооц}(n)} - \text{ҮАЗ}^*_{\text{Гүйц}(n)}) - (\text{ҮАЗ}_{\text{Тооц}(n-1)} - \text{ҮАЗ}_{\text{Гүйц}(n-1)});$$

$$\text{ҮАЗ}^*_{\text{Гүйц}(n)} = \text{ҮАЗ}_{\text{Тооц}(n)} - (\text{ҮАЗ}_{\text{Тооц}(n-1)} - \text{ҮАЗ}_{\text{Гүйц}(n-1)}) + \text{ОШҮАӨ}_{\text{Гүйц}(t-1)};$$

- ҮАЗ - Үйл ажиллагааны зардал;
ОШҮАӨ_{Гүйц(n-1)} - Тарифын зохицуулалтын өмнөх хугацааны сүүлийн өмнөх жилд гарсан онцгой, нэг удаагийн шинжтэй үр ашгийн өсөлт;

9.3. Дараагийн тарифын зохицуулалтын хугацааны тариф мөрдөх жилийн тарифыг 5-д заасны дагуу хянаж тооцсон борлуулалтын орлогын шаардагдах хэмжээн дээр шилжүүлэх үр ашгийн хуваарилалтыг нэмж тогтооно.

$$\text{БОШХ}_{(n+i)} = \text{БОШХ}_{\text{Хянасан}(n+i)} + \text{ШҮА}_{(n+i)}$$

- БОШХ_{Хянасан(n+i)} - Аргачлалын 5-д заасны дагуу хянасан тухайн жилийн БОШХ;
ОШҮАӨ_{Гүйц(n-i)} - Тарифын зохицуулалтын өмнөх хугацааны сүүлийн өмнөх жилд гарсан онцгой, нэг удаагийн шинжтэй үр ашгийн өсөлт;

10. БУСАД

10.1. ТЗЭ нь тарифын тооцоог хянахад шаардлагатай дараахь материалыг хавсаргана. Үүнд :

- а) Цахилгаан, дулааны эрчим хүчний тарифын тооцоо /Хүснэгт №1/
 - б) ТЗЭ-ийн бүрэн өөрийн өртөг, нийт зардлын санал, сүүлийн 3 жилийн гүйцэтгэл /Хүснэгт №2/
 - в) Үйлдвэрлэх ТЗЭ-ийн дулааны эрчим хүчний санхүүгийн алдагдлын тооцоо /Хүснэгт №3/
 - г) Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах ТЗЭ-ийн техник, эдийн засгийн үзүүлэлтийн өмнөх онуудын гүйцэтгэл, санал /Хүснэгт №4, 5, 6, 7/
 - д) Тарифын тооцоонд ашигласан түлш, түүхий эд, сэлбэг материал, үйлчилгээний үнэ, тарифын жагсаалт
- 10.2. Тухайн тарифын зохицуулалтын хугацааны тариф мөрдөх жилүүдэд өмнөх тарифын зохицуулалтын хугацаанд гарсан хэмнэлт, үр ашгийг Хавсралт 1-д заасан схемн дагуу хуваарилж шилжүүлнэ.

---oOo---

Үр ашгийг хуваарилж шилжүүлэх схем

1-р зохицуулалтын хугацааны эхний жил	t+1
2-р зохицуулалтын хугацааны эхний жил	n+1
Онцгой шинжтэй үр ашгийн өсөлт	X
Хөрөнгийн өгөөжийн хувь	r

Тарифын зохицуулалтын хугацаа	0		I					II				
Тариф мөрдөх жил	t-1	t-0	t+1	t+2	t+3	t+4	t+5=n	n+1	n+2	n+3	n+4	n+5
Төлөвлөсөн үйл ажиллагааны зардал	$a_{(-1)}$	a_0	a_1	a_2	a_3	a_4	a_5	$a_{(5+1)}$	$a_{(5+2)}$	$a_{(5+3)}$	$a_{(5+4)}$	$a_{(5+5)}$
Гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардал	$b_{(-1)}$	b_0	b_1	b_2	b_3	b_4	$b_5=a_5-c_4+X$	$b_{(5+1)}$	$b_{(5+2)}$	$b_{(5+3)}$	$b_{(5+4)}$	$b_{(5+5)}$
Зардлын хэмнэлт буюу үр ашиг	$c_{(-1)}=a_{(-1)}-b_{(-1)}$	$c_0=a_0-b_0$	$c_1=a_1-b_1$	$c_2=a_2-b_2$	$c_3=a_3-b_3$	$c_4=a_4-b_4$	$c_5=a_5-b_5$					
Үр ашгийн өсөлт			$d_1=c_0-c_{(-1)}$	$d_2=c_2-c_1$	$d_3=c_3-c_2$	$d_4=c_4-c_3$	$d_5=c_5-c_4$					
Шилжүүлэх	t+1			d_1	d_1	d_1	d_1	d_1				
	t+2				d_2	d_2	d_2	d_2	d_2			
	t+3					d_3	d_3	d_3	d_3	d_3		
	t+4						d_4	d_4	d_4	d_4	d_4	
	n=t+5							d_5	d_5	d_5	d_5	d_5
Шилжүүлэх нийт ҮАӨ								$e_1=d_1+d_2+d_3+d_4+d_5$	$e_2=d_2+d_3+d_4+d_5$	$e_3=d_3+d_4+d_5$	$e_4=d_4+d_5$	$e_5=d_5$
ТЗЭ-д хуваарилах ҮАӨ								$g_1=e_1 \times 0.5/(1+r)^1$	$g_2=e_2 \times 0.5/(1+r)^2$	$g_3=e_3 \times 0.5/(1+r)^3$	$g_4=e_4 \times 0.5/(1+r)^4$	$g_5=e_5 \times 0.5/(1+r)^5$
БОШХ=Үйл аж-ны зардал + ҮАӨ								$a_{(5+1)}+g_1$	$a_{(5+2)}+g_2$	$a_{(5+3)}+g_3$	$a_{(5+4)}+g_4$	$a_{(5+5)}+g_5$